

Шумога Kazeku

Хойд нутгийн

АРАШИ

НЭРТ ҮНЭЭ



Шимода Кагеки

Хойд нутгийн Араши нэрт үнэг

Япон хэлнээс орчуулсан

Хянан тохиолдуулсан

Хянагч

Дизайнер

Зураач

Т.Энхлүрэв

Ж.Дашдондог

О.Мөнхтуяа

Ж.Гэрэлмаа

Т.Дэлгэрмаа

П.Зулбаяр




Хэвлэн нийтлэлийг  
Интерпресс ХХК

Шумога Казеку

Хойг нутгийн

АРАШИ



НЭРТ ҮНЭГ

## ***Амьтны хэл мэддэг зохиолч***

Толгойтой үсээ өнгө ялган будсан, алиалагч шиг алаг эрээн хувцастай нэг сонин хүнтэй Токиод танилцаж билээ. Тэр бол амьтны сэдэвт зохиолоороо нэрд гарсан хүүхдийн зохиолч Кагеки Шимода гэгч байлаа. Өөрийнхөө үлгэрийг хөгжмийн чимэг, зургийн үзүүлбэртэйгээр хүүхдүүдэд ярьж өгдөг гэнэ. Нэг бодлын жүжигчин ч юм шиг. Өндөр хөгжилтэй орнуудад үлгэр хүүрнэгч гэдэг тусгай мэргэжлийн хүмүүс байдаг ажээ. Шимода сан бол аль алиныг нь хавсарч хийдэг авьяас билэгт зохиолч юм байна. Эцэг эхчүүд хүүхдээ дагуулан ирж түүний тоглолтыг сонирхон үздэг гэнэ. Тоглолт нь тасалбартай бөгөөд нэг удаагийн орлогоо "Монголын хүүхдийн соёлын сан"-д хандив болгон илгээж байсан. Би түүний "Хурдан хөлтийн ээж", "Хойт нутгийн Араши нэрт үнэг", "Сайхан сэтгэлт арслан", "Заан хүүгийн үлгэр" зэрэг зохиолын хадмал орчуулгыг уран сайхны хэлбэрт оруулан монголчилж суухдаа нулимсаа тогтоон ядаж байсан. Зохиолыг нь уншихад "Амьтны хэл мэддэг болоод зовлонт амьдралыг нь уудлан гаргаж дээ" гэмээр. Ялангуяа, "Заан хүүгийн үлгэр" номын хуудсан дээр нулимс дусахгүй өнгөрнө гэж ер үгүй. Араши нэрт үнэгний амьдрал ч гэсэн маш өрөвдөлтэй. Тэрээр тав зургаахан жилийн өмнө том хүний зохиол бичиж байжээ. Нэг удаа хүүхдийн цэцэрлэгт Андерсений үлгэрүүдийг урнаар уншиж өгч байхыг сонсоод өөрөө бичиж үзмээр санагдсан гэнэ.

-Яагаад амьтны сэдвийг сонгов? гэтэл,

-Манай Япон хүүхдүүд амьтнаас улам л холдсоор байна. Танайд бол мал адуустай ойр харьцаж байдаг болохоор амьтныг хайрлах нь илүү гэсэн. Миний дотно танил Кёкүшүзан Батбаяр надад тэгж хэлсэн. Амьтан хайрлах сэтгэлийг хүүхдэд төрүүлэх зорилгоор шулуулан бичсээр байтал нэг мэдэхэд дөч орчим ном гарсан байна гэж Шимода зохиолч хэллээ. Гарынхаа үсгийг зурж өгсөн Араши хэмээх зовлонт үнэгний тухай ном нь Дэлхийн банкны "Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл"-д шалгарсан тул япон хэлтэй Т.Энхлүрэвээр орчуулуулж, монголжуу болгох тал дээр нь бага сага тус дэм үзүүлж, номонд хорхойссон багачууд та бүхний өмнө дэлгэж байна.

*Жамбын Дашдондог*

## ХОЙД НУТГИЙН АРАШИ НЭРТ ҮНЭГ

Араши нэрт үнэг нүхэн гэрийнхээ товцог дээр гарч зүүн тийш хараа сунгав. Хаашаа ч харсан элчилгүй өргөн тал хөндий. Гурван муу гавар нь шил даран гарч ирэв. Эвшээлгэж суниах нь нойрноос дөнгөж сэрснийх. Тэд Арашийг харснаа тайвшрав бололтой. “Нар ч цухуйх нь, ан авдаа гаръя даа. Удахгүй намар болно. Эдний маань бие даах цаг ч ирнэ. Наана нь зааж сургах юм хэчнээн их” хэмээн тэр бодов. Нарны туяанд Арашийн үс ёстой л галт үнэг мэт алтран байлаа. Өнгөрсөн үеийн нэгэн дурсамж өнөө хүртэл түүний толгойноос гардаггүй. Энэ удаа ч бас ....

Найман жилийн өмнө сөн. Түүний хараачлан буй зүүнтээх их талд Араши үнэг, дүү Фүбүкийн хамт төрж байжээ. Эцэг нь бас л тэнд төрсөн эрэлхэг үнэг байсан санж. Ээж нь уян зөөлөн, ухаалаг сайн үнэг байлаа. Жаахан үрээ элдвээр бөөцийлөн өсгөж, нөгөө хоёр нь ч эх эцгээ даган ийш тийш явахтайгаа болов. Нэг өдөр эцэг эхээ дагаж анд явсан хоёр, хүн гэгчийн суудаг хэд хэдэн байшинг олж харжээ. Сэрмүүн бэлчээрт үхэр сүрэг идээшилнэ. “Гурван жилийн өмнө аав нь энд ирж тоглодог байхад юу ч байгаагүй. Та нар харин хүмүүсийн гэр байшинг олж хардаг, азтай хүүхдүүд юм” гэж ээж нь хэллээ.






Гол уруу тонгойтол сүрэг зэрлэг нугас үзэгдэв. Аав нь өвс зулгааж толгой дээрээ тавин, ус уруу сэмээрхэн орж нугас уруу дөхлөө. Ай, гэхийн хооронд л нэг нугас бариад авлаа даа. Сурсан эрдэм ээ гэж! Эх нь хоёр хүүдээ “Үүнийг л сурч ав!” гэнэ. Тэд яван явсаар нэлээд алсалжээ. Туулайн анд гарсан бололтой. Эцэг үнэг дагалдагсдаа хэсэг сөөгт нууж орхиод цаашлав. Тэгтэл нэгэн туулай ганцаар яваа үнэгийг харж зогссоноо ойртох янзтай, “Аав ганцаараа яана даа” гэж Араши шаналж байлаа. Ээж нь харж, “Энэ бол аавын чинь жүжиг. Туулай сониуч болохоороо алхам алхмаар дөхөж байгаа нь тэр” хэмээн шивнэнэ. Туулай ойртсоор л. Үнэг өөдөөс нь харсаар л. Туулай гэнэт годхийн алга болов. Юу болов? гээд дээш өлийвөл томоо гээчийн бараан шувуу тэнгэрт тойрог татах мэт эргэлдэн байлаа. “Бүргэдээс болгоомжил! Хурдан нуугд!” гэсэн эцгийн үгээр тэд гялсхийн нүхэнд шургав. Ер нь тэд өөрийн гэрээс гадна хэд хэдэн нүхтэй. Дайснаас нуугдана, бас бороотой үед хоол хүнсээ нөөцөлнө.

Хоёр гавар тийнхүү амьдрах аргад суралцсаар намартай золгов. Хулгана зурам мэтийг өөрсдөө ч эд







бад хийлгэхтэйгээ болжээ. Харин нугас, туулай мэт нь амаргүй ан.

Одоохондоо аав ээжийнхээ хэрхэн ан хийхийг харж хэвтэхээс өөр аргагүй. Нэг удаа Араши үнэг “Туулайг яагаад ч гүйцэхгүй юм байна” гэсээр эргэж ирэхэд аав нь дуугүй л инээн зогссон билээ.

Өвөл боллоо. Хаа сайгүй цасан хучлага тогтоход ан хийж, хоолоо олно гэдэг тийм ч амаргүй дээ. Юу олдсоноо л идэхээс өөр аргагүй. Гэвч эцэг нь яаж ийж гаварнууддаа өл хоол залгуулсаар л байлаа. Бүр арга ядвал модны үндэс ч болов ухаж, хорхой шавж олж өгнө. Нэг өдөр Араши гавар нэлээн зайдуу газар өөрсөдтэйгөө төстөйдүү сүрэг давхилдахыг олж харав. Аав уруугаа гайхан хартал “Нохой гэдэг юм. Бидэнд дайсагнах нь юуны магад” гээд хавьтуулсангүй. Цааш явтал нүд аньсан хэдэн гавар таарав. Араши “Ноход барив уу?” гэхэд аав нь

“Хавар төрсөн нялхас байна. Ан хийж чадалгүй өлбөрч үхсэн ч байж магад” гэлээ. Араши “Даанч өрөвдмөөр” гэхэд эх нь

“Аль нэгнээр өрөвдүүлж амьдардаг газар биш шүү, энэ!” хэмээн тас түс хэллээ.

“Хоол олох аргаа өөрөө л



сурахгүй бол үүнээс өөр зам тосохгүй юм байна” гэж Араши өөртөө өгүүлэв. Шөнө хүйтэн салхи хавирга нэвт салхилна. Араши ааваа даган урагшилтал амандаа том шувуу зуусан үл таних нэгэн үнэг тааралдав.

- Энэ юун үнэг вэ?

- Гурван жилийн өмнө нүдэнд харагдсан л үнэг байна. Энэ газар хүмүүс нүүж ирэхэд алга болсон юм. Түүнээс хойш харалгүй уджээ.

-Амандаа ямар шувуу зуусан юм бэ?

-Тахиа гэдэг юм. Хүний юм хулгайлдаг муу үнэг!

Хоёр өдрийн дараа нөгөө үнэг аанай л тахиа зуусаар яваа нь үзэгдэв. Түүнээс хойш бас л хэд хоног өнгөрлөө. Эцэг нь Араши гавраа дагуулан хулгайч үнэгний замыг отов. Нөгөө гайхал ч тахиа зуусаар айсуй. Эцэг нь “Байз!” гэж хулгайч үнэгийг зогсоогоод “Хүмүүсийн юмыг хулгайлахаа боль! гэсгээл нь хэзээ нэг цагт чамд биш ч бидэнд ирнэ. Ерөөсөө ч хулгай хийж амьдрах шиг ичгүүртэй юм



алга!" гэв. Хулгайч үнэг гайхан зууж явсан тахиагаа өвсөн дунд тавилаа. Аав нь түр ажигласнаа шууд л барилцаад авлаа. Тэр хоёр үснээсээ зулгаалцан цусаа гартал тэмцэлдлээ. Нэг их удалгүй хулгайч үнэгийг буулган авснаар тулалдаан дуусав.

Арашийн эцэг нь "Дахин ингэж явбал аминд чинь хүрнэ шүү!" гэж хэлээд хулгайч үнэгийг суллан тавив. Тэр амь наана там цаана чавхадсаар хусан ойд шургалаа.

- Аав! Энэ тахиаг яах вэ?

- Идвэл хулгайч үнэгний нүгэлт явдлыг давтах болно.

- Ааваа! Тэгвэл туулайн анд явах уу?

Намар шувтарч, өвс гандаж, навч шарлав. Арын уулс цасан дахаа нөмөрлөө. Аав нь "Яаж амьдарна даа" гэх шиг цастай уулсыг ширтэнэ. Хавар төрсөн гаврууд нь амиа даах хэмжээнд хүрсэн бололтой. Дараах нэгэн үдэш Араши Фүбүки хоёр эцэг эхээсээ өрх тусгаарлан амьдрахаар алсын замд гарах гэж байв. Тэр хоёр эцэг эх үрүүгээ буцаж гүйгээд байхааргүй алс холыг зорих болжээ. Яг тэр мөчид аав ээж хоёрынх нь ард хүн зогсож буй харагдав гэнэ. Нэг нь буу барьсан том хүн, нөгөө нь жаахан хүүхэд.



“Аав, цаана чинь!” хэмээн хашгиран дөхөж очтол нөгөө том хүн “Манай тахиаг зөөсөн хулгайч үнэг” гээд гох дарав. Буу ч тасхийж, аав нь үсрэн савж уналаа. Араши ч бас ёолон гасалж, хөдөлж чадахаа болив. Тэгэхнээ, эцгийнх нь биеийг зөгийн үүр мэт сийчсэн үрлэн сумны нэг хэсэг нь Араши дээр тусчээ. Ээж, Фүбүки хоёр нь үхлээс өрсөн нүхэндээ шургасан юм байх. Буутай хүн Арашид ойртон “Амь нь гараагүй байна” гээд амыг нь түүн үрүү чиглүүлэв. “Аав аа! Битгий буудаач! Наадах чинь биднээс ялгаагүй, гавар байна шүү дээ!” гэж уйлж зуурсан хүүгийнхээ дуунаар нөгөө хүн буудахаа болилоо. Арашийн шарх тэсэхийн аргагүй өвдөж, нэг мэдэхнээ ээж нь долоож байлаа.

- Өвдөж байна уу?

- Үгүй дээ, зүгээр. Үнэндээ бол их өвдөж байлаа. Гэвч Араши тэсэхийн ихээр тэсч, тэвчихийн ихээр тэвчиж байлаа.

- Ингэхэд Фүбүки хаачсан бэ?

- Чамайг энд надтай хамт авчраад гараад явсан. Хажууд нь уйлаад яахав гэж бодсон байх. Ээж нь хорьсонгүй.

- Аа тийм үү?

- Хүү минь, биед чинь байгаа сумыг авъя.





Өвдөнө шүү! Чи тэсээрэй! Чингээд зүүн хойд хөл, зүүн мөр, баруун эгэм гуравт буй сумны шархыг нь долоож байснаа эхлээд зүүн хойд хөлийнх нь шархыг соёогоороо нэвт хатгав. Араши ёолж байсан ч тэвчсээр хэвтлээ. Зүүн мөрнийх нь шархыг соёогоороо цоолоход цус бялтав. Ингэсээр байтал лав дөрөв таван цаг өнгөрөв. Баруун эгмэнд орсон сум нь булчинд гүн шигдсэн байв. Гэвч ээж нь түүнийг хурц соёогоороо сэт татан, яах ийхийн зуургүй авч хаяж чадлаа.

“Тэвчээрэй, сайн хүү!” Ээж нь ингэж магтаад шархыг нь даруй хоёр цаг долоов. Өвдөх нь арай багассан болоод ч тэрүү Араши түр дугхийв бололтой. Гэвч муу ээж нь хүүгийнхээ үс арьсанд наалдсан цусыг долоосоор л байлаа. Дараагийн өдөр ан хийхээр гадагш гарав.

Араши тэр агшинд нэлээн бөх унтаж байснаа улаан цусаа савируулан унаж байсан эцгийнхээ дүр төрхийг зүүдэндээ хэд хэдэн удаа харж, гэнэт муухай хашгиран сэрлээ.

Яваандаа зүүн мөр, баруун эгэмнийх нь шарх аньж байлаа. Харин зүүн хойд хөлийнх нь шарх нь аниагүй боловч бага зэрэг хөдлөхтэйгөө болов. Ээж нь Арашид хүчтэй давалгаалах далайн уснаас авчирч өгч байлаа.



Араши их халуурч байв. “Хүлээж байгаарай! гээд ээж нь нар мандах үед нүхэн гэрээсээ гарсан боловч их холдсонгүй.

Арашид ээжийнх нь сэтгэл санаа тавгүй байгаа нь мэдэгдэх тусам түүний сэтгэл санаа хэцүү байв.

Ээж нь орой болсон хойно нэгэн төрлийн өвс зуусаар ирэв. Тэр өвсийг сайтар зажлан идсээр, өдөр ирэх тусам Арашигийн зүүн хойд хөл нь бага багаар эдгэн байвч тэсэхийн аргагүй өвдөж байсан ч Араши шүд зуун тэвчиж байв. Дараагийн өдөр өнгөрч хоёр гурав хоноход шарх нь аньж байлаа.

Ээж нь их баярлан “Ээж нь гараад ирье. Харин чи нааш цааш явж дасгал хийж байгаарай!” гээд гарч одов. Хойноос нь харж хоцорсон Араши “Хөөрхий муу ээж минь яасан их тураа вэ? Хэрэв би зүгээр байсан бол ээж юундаа ядарч зүдрэх билээ” гэж бодоод хоёр нүдэндээ нулимстай хоцров. Дахиад л догшин ширүүн өвөл. Шөнөдөө шуурга тавилаа. Гэвч хөөрхий муу ээж нь идэх юм хайсаар гэрээс гарлаа. Араши нааш цааш алхлан хүлээнэ. Тээр орой ээж нь нил цас болчихсон ирэв. Амандаа хулгана зуужээ. Гуйван дайван байвч нүүрэнд нь инээд баясал гэрэлтэнэ.

- Миний хүү, ид ид!



- За за идлээ. Өдөржин хоосон байсан юм. Үнэндээ бол Арашид хоол хайж эх үнэг өөрөө хэлэн дээрээ юм тавьдаггүй байжээ.

- Миний хүү идэхгүй бол болохгүй шүү! Ээж нь жаахан нүдний хор гаргаатахъя гээд ээж нь хажуулав. Араши авчирсан хулганых нь талыг юу ч идээгүй ээждээ үлдээлээ. "Ээж ээ, босоорой! Талыг нь танд үлдээлээ. Идээрэй!" Ийнхүү дуудавч нэг л сэрэх янзгүй. Царай нь унтаж байгаа гэхэд нэр л өөр. Ээжийнхээ хамарт хошуугаа хүргэвэл аль хэдийн амьсгал хураасан байлаа. Хүүдээ идэх юм олох гэж аймшигт шуурганд амь хайргүй тэмцээр



яваад ийм болжээ. Аав нь ч ийм л дулаан сайхан сэтгэлтэй үнэг байсан. Араши шөнөжин ээжийнхээ дэргэд хэвтэж, зөөлөн үсийг нь илбэн таалсаар байлаа. Үсний нь сор харанхуйд ч гялалзан, амьд байгаа мэт санагдана.

“Баяртай, ээж ээ! Араши хүү нь үнэг шиг үнэг байж чадна” гээд ээжийнхээ дэргэдээс холдлоо. Нүхэн гэрээсээ гарч, цастай уудам тал дундуур баруун зүгийг барин гэлдрэв.

Араши энэхүү түүхээ эргэн дурсахдаа бяцхан хөөрхөн гавруудаа өнгийн харж, “Эцэг эхээс уламжлан ирсэн амьдрах ухааныг тэдэндээ зааж зурахаас!” хэмээн бодож зогсов. Тэгтэл хүүхдүүдийн ээж нь гэрээсээ гарч ирлээ. Жаахан гаврууд ч ээждээ эрхлэн наадна. Араши товцог дээрээс алгуурхан бууж, хэдэн муу гавраа дагуулсаар ан авын замд гарлаа.





Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.